

“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 4 сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

“Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 1 сарын 22-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, Бодь цамхаг, 2-р давхар, Дорчестер клуб, Улаанбаатар өрөөнд эхлэв.

Хурлын дэгийн дагуу 10:05 хүртэл ирц бүртгэсэн.

Тооллогын комиссын дарга Б.Мөнхзул: 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн дугаар номер 1 Улаанбаатар хот. Монгол Улсын Компанийн тухай хуулийн хуулийн 63.7, 67.3 69.1 дэх хэсэгт Хот Девелопмент ХК-ийн дүрмийн 3.14 болон Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссийн дүнг үндэслэн тогтоох нь 1-т “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 28,921,521 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 4 (дөрөв) хувьцаа эзэмшигчид оролцож, нийт саналын эрх бүхий 28,970,054 ширхэг хувьцааны 99.83% хувь болж байгааг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй. 2-т Компанийн тухай хуулийн 69.1 болон 69.2 дахь заалт, компанийн дүрмийн 3.14 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 99.83% эзэмшдэг хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: За тооллогын комиссын дарга Б.Мөнхзул танаа баярлалаа. Одоо Хурлын дарга Энхбаатар овогтой Баярбат нээж үг хэлээд хурлын дэгийг танилцуулна.

Хурлын дарга, хувьцаа эзэмшигч Э.Баярбат: Хот Девелопмент ХК-ийн 2023 оны үр дүн болсон ээлжит хурлыг Компанийн хуулийн дагуу 4 сарын 22-ны өдөр буюу өнөөдөр зохион байгуулж байна. Өнөөдрийн хурлаар нийтдээ 5 асуудлын хүрээнд хэлэлцэхээр байгаа. Хурлын дэг дотор хэлэлцэх асуудлын жагсаалт багтчихсан тул жагсаалтыг тусад нь танилцуулахгүйгээр дэгээ танилцуулъя. Өнөөдрийн хуралд нийт одоогийн байдлаар бол 4 хувьцаа эзэмшигч оролцож байгаа. За хурал бол 10 цагтаа эхлээд 12 цаг хүртэл үргэлжлэхээр товлогдсон байна. Хурлын ирцийг тооллогын комиссын дарга бүртгээд дууссан. Ирцийн үр дүнг бол мэдээллэсэн. Хэлэлцэх асуудлуудын нэгдүгээрт 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг дүгнэсэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүгнэлтийг ХЭХ-аар хэлэлцэн батлана. Хоёрдугаар асуудал нь 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дүгнэсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батална. Гуравдугаарт нь 2024 оны үйл ажиллагааныхаа төлөвлөгөө болон үүнтэй дагалдан гарах төсвийг батлах шаардлагатай байгаа. Дөрөв дэх хэлэлцэх асуудал нь ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай тогтоолыг хэлэлцэж батална. Тавдугаар хэлэлцэх асуудал бол ТУЗ-н гишүүдийг сонгох тухай юм.

За ингээд 11 цаг 10 минут хүртэл хурлын дэгийн дагуу эдгээр 5 асуудлыг хэлэлцээд саналыг үндэслэн шийдвэрлээд явна. За эдгээр 5 асуудлын хүрээнд 11 цаг 10 минут хүртэл бид нар төлөвлөсний дагуу хуралдах ёстой. Үүний дараа асуулт хариултын 10 минут яваад, санал хураалт 10 минутын турш буюу 11:20-оос 11:30-ийн хооронд, хурлын завсарлагааг 10 минут байхаар төлөвлөсөн. Хурал завсарлаж байх хооронд тооллогын комисс үр дүнгээ танилцуулах 5 минут байгаа. Тэгээд хурлаас гарах шийдвэр тогтоолыг мөн дараагийн 10 минутад танилцуулаад хурлыг 11:55-аас 12:00-ийн хооронд хаах хурлын дэг, төлөвлөгөөтэй байна.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: Хурлын дарга Э.Баярбат танаа баярлалаа. Одоо ингээд хувьцаа эзэмшигчдээс авах саналын хуудсыг тарааж өгье. Та бүхэн санал авах хуудсын заавартай танилцаад, тодруулж асуух зүйл байвал асуугаарай. Ингээд хэлэлцэх асуудлуудтай

танилцъя.

Хэлэлцэх асуудал 1 : “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлттэй танилцах.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: Хэлэлцэх асуудлаа танилцуулах уу? “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлттэй танилцах байгаа. Хараат бус аудитын дүгнэлт нь бол бичгээрээ гарсан та бүхэн дэлгэцэн дээр харж байгаа байх. За Пантер мидланд аудитын гаргасан дүгнэлтийн агуулгыг нь товч уншиж танилцуулбал : Санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон гаргасан санхүү байдал, орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, тодруулгуудаас бүрдсэн. Санхүүгийн тайлан нь Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулж байна. Аудит хийхдээ аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн, уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага эсэхэд харуулсан. Бид Нягтлан бодогчийн ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон аудитын тухай Монгол Улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон нягтлан бодох бүртгэлийн ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Өөрөөр хэлэх юм болбол ямар нэгэн байдлаар хараат ажиллаагүй хараат бусаар энэ тайланг гаргасан гэдгээ ингээд аудитын дүгнэлтийнхээ үндэслэл хэсэгт бол оруулж өгсөн байсан. Тэгээд санхүүгийн тайлангийн аудитад аудитын хүлээх хариуцлагаа тусгаад өгчихсөн байсан. Ерөнхийд нь дүгнээд хэлэх юм бол аудитын тайланг гаргахдаа хараат бусаар, үнэн зөв гаргасан гэдгээ “Хот Девелопмент” ХК-ийн удирдлагад ирүүлсэн захидалд дурьдаж, бичгээр ирүүлсэн.

За тэгээд аудитын дүгнэлт бол ингэж гарсан байгаа. Санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлттэй танилцсан ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай гэсэн тогтоол слайд дээр харагдаж байна. Та бүхэнд уншиж танилцуулъя. Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 3-р зүйлийн 3.13.9 дэх заалт, 2024 оны 04 сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь. “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай гэж оруулж ирж байгаа.

Одоо хувьцаа эзэмшигчид маань энэ асуудал дээр саналаа хэлээд, нөгөө саналын хуудсаа бөглөөд яваарай. Энэ бол тогтоолын төсөл байгаа. Та бүхний өгсөн саналын хуудсыг үндэслэж байгаад эцсийн байдлаар бол баталгаажна. Тооллогын комиссын дүнг үндэслэнэ гээд дандаа орчихсон байгаа. Хувьцаа эзэмшигч нараас ямар нэг саналгүй бол дараагийн хэлэлцэх асуудлаа үргэлжлүүлъя.

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго : Санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт цаг тухайд нь зохицуулагч байгууллагуудад хүргэгдэж байгаа юу?

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: Тийм. Хуулийн дагуу 4 сарын 30-ны дотор буюу бид 2024.03.13-нд СЗХ болон МХБ-д аудитын тайланг хүргүүлж, мөн Өдрийн сонингоор санхүүгийн тайлангийн дүгнэлт болон тайланг нийтэд мэдээллээд явж байгаа.

Хэлэлцэх асуудал 2 : “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Энэ асуудлын хүрээнд бол бид нар 2023 оны үйл ажиллагааныхаа тайланг СЗХ-ноос баталсан маягтын дагуу МХБ болон СЗХ-нд тайлант хугацаанд нь буюу 3 сарын 13-нд бол тус тус хүргүүлчихсэн байгаа. Энэ тайлантай холбоотойгоор ТУЗ-өөс дүгнэлт гардаг. Энэ яадаг дүгнэлт вэ гэхээр 2023 ондоо энэ “Хот девелопмент” ХК нь ямар үйл ажиллагаа эрхэлсэн юм одоо ХЭХ хуралдсан юм уу хуралдсан бол ямар асуудлыг шийдвэрлэсэн юм санхүүгийн тайлан нь ямар байгаа юм гээд ерөнхийд нь багцлаад дүгнэсэн.

Одоо 2024 оны 3 сарын 11-ний өдөр ТУЗ-өөс гаргасан дүгнэлт байгаа. ТУЗ-ийн дүгнэлтийг болохоор ХЭХ-аасаа баталдаг энэ ТУЗ-ийн дүгнэлт нь үнэн зөв юм уу үгүй юм уу гээд энэтэй холбоотойгоор ХЭХ-ын тогтоолын төслийг бэлдсэн байна.

Тогтоолын төслийг уншиж танилцуулбал. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 3-р зүйлийн 3.13.9 дэх заалт, 2024 оны 04 сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь. Нэгдүгээрт “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай. Ийм агуулгаар тогтоолын төсөл бэлдсэн байгаа.

Хувьцаа эзэмшигчид нар энэ тогтоолын төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтэй байх юм бол одоо саналаа илэрхийлж болно. Хэрэв тогтоолын төслийг энэ чигээр нь баталъя эсвэл татгалзъя, түдгэлзье гэх юм болбол та бүхэнд тарааж өгсөн саналын хуудсан дээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэдгээ тэмдэглэгээ хийгээд ард нь гарын үсгээ зурах байгаа шүү. Хэрвээ татгалзсан байх юм болбол ямар шалтгаанаар татгалзаж байгаа юм тэрийгээ бас товчхон тайлбар биччихэж болно. Тэмдэглэгээ хийхдээ нэмэх тэмдэг юм уу зөв тэмдэглэгээ хийж энэ дөрвөлжин дээр нь тэмдэглэнэ гэсэн үг.

Хувьцаа эзэмшигч Б.Чулуун-Эрдэнэ: Хамгийн сүүлд хүмүүсийн санал авна биз дээ тэ? Тухайн үе бүрт тэмдэглээд явж байна уу?

Хурал зохион байгуулах комиссын дарга: Тухайн үе бүрт нь тэмдэглээд явчихвал хувьцаа эзэмшигчдэд амар байх.

Хэлэлцэх асуудал 3. “Хот Девелопмент” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв багтах.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: Хэлэлцэх асуудлын 3 руу орж ирсэн байна. “Хот Девелопмент” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах гэж байгаа. 2023 онд “Хот Девелопмент” ХК нь өмнөх жилүүдийг бодвол нилээн их ажлуудыг төлөвлөж хийж гүйцэтгэлээ. Үүнээс дурьдвал : Компанийн хувьцааны тоог нэмэгдүүлэх буюу хаалттай хүрээнд нэмж хувьцаа гарган ажиллаа. Энэхүү ажлыг амжилттай зохион байгуулж “Финова Корпорейшн” ХХК нь хуучнаар “Занн Корпорейшн Монголиа” ХХК нь нийт хувьцааны 70,76 хувь буюу 2,050,000 ширхэг хувьцааг эзэмшдэг болсон. Үүнтэй холбоотойгоор нийт 17,670,000 төгрөгийн зардал бодитоор гарсан байна. Мөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрөл авахтай холбоотойгоор ISO 27001-н баталгаажуулалтын аудитаар орлоо. Үүнтэй холбоотойгоор 28,262,175 төгрөгийн бодит зардал гарсан байна. Мөн хүний нөөцийн бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлж, чадварлаг боловсон хүчнээр багаа бүрдүүлэх зорилгын хүрээнд тодорхой хэмжээнд чадварлаг боловсон хүчнээр баг бүрдүүлэн ажиллаж байна. За 2024 онд компанийн бизнесийн үйл ажиллагааг идэвхжүүлэн тэлэх, нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээг бууруулах, ашигт ажиллагааг бий болгох, цаашлаад хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилдаг компани болохын төлөө зорилго тавин ажиллахаар төлөвлөсөн байгаа. Энэхүү зорилгынхоо хүрээнд бол дараах зорилтуудыг хэрэгжүүлж хийхээр төлөвлөсөн. Нэгдүгээрт Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг авах. Өмнөх жил бид төлөвлөгөөндөө оруулж байсан. Хэд хэдэн шаардлагуудыг хангаж зөвшөөрлийг авахаар зорьж байна. 2-т нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тусгай

зөвшөөрлийг авахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах, 3-рт Хүний нөөцийн бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлох, чадварлаг боловсон хүчнээр багаа бүрдүүлэх. 4-т нь шинэ төсөл хөтөлбөрийг боловсруулна, хэрэгжүүлнэ, 5-д нь хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээ мэдээллийг нээлттэй, ил тод, түргэн шуурхай хүргэх дотоод тогтолцоог бий болгохоор зорин ажиллаж байна. За ингээд 2024 оны Хот Девелопмент компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө төсвийг батлах ХЭХ-ын тогтоолын төсөл слайданд гарч ирсэн тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дэх заалт, Компанийн дүрмийн 3-р зүйлийн 3.13.10 дэх заалт, 2024 оны 04 сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь. 1-рт “Хот Девелопмент” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт нэгээр баталсугай. Хавсралт нэг нь болохоороо одоо бидний сая ярилцсан энэ зорилтуудаа хавсралтаар оруулж өгчихсөн байгаа. 2-т нь Хот Девелопмент ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төсвийг дараах хүснэгтийн дагуу баталсугай. За та бүхэн слайд дээрх хүснэгтийг харж байгаа байхаа.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: За энэ саяны тогтоол байна. Энэ хавсралт 1 дээр болохоор түрүүн ярилцсан 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө ярьсан 5 заалтынхаа дагуу батлагдахаар төлөвлөгдсөн, хавсралт 2 дээр төсөв байна. Хувьцаа эзэмшигч нарт маань санал байвал хэлээрэй. Магадгүй бидний тооцоолоогүй, анзаараагүй зүйл байвал төсөл болохоор саналыг тусгаад засварлаад явчихаж болно шүү.

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Төсөв дээр харин сайн нягталж харж саналаа хэлье. ISO аудит одоо дахин баталгаажуулалтаар орох билүү?

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: Тийм. Өмнөх аудитаас яг нэг жилийн дараа буюу 2024 оны 5 сарын 11-ний өдөр оруулахаар төлөвлөж байна.

Хувьцаа эзэмшигч Э.Баярбат: Аан за ойлголоо. Төсвийг дахин сайн хараад ярилцая .

Хувьцаа эзэмшигч Б.Чулуун-Эрдэнэ: Тэгье.

Хэлэлцэх асуудал 4. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай тогтоолыг батлах тухай

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: За 4 дэх хэлэлцэх асуудал бол ТУЗ-аас гаргасан ногдол ашиг тараахгүй тухай тогтоолыг баталгаажуулах байгаа. Өмнө нь дурьдсанчлан “Хот Девелопмент” ХК нь 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр нийт 1,1 тэрбумын алдагдалтай байгаа. Тиймээс шууд тогтоолын төслөө уншаад явчих уу?

Хувьцаа эзэмшигч Э.Баярбат: За тэгье.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, Компанийн дүрмийн 3-р зүйлийн 3.13.10 дахь заалт, 2024 оны 04 сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь : Нэг “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан 2023 оны тайлант хугацаанд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй байх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг баталсугай. Энэхүү асуудал дээр бүгд санал нэгтэй байгаа байх. Цаг алдалгүй цааш явах уу?

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Тэгье. Угаасаа ойлгомжтой шийдвэр.

Хэлэлцэх асуудал 5. Хот Девелопмент ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай.

Хэлэлцэх асуудал 5 нь бол “Хот Девелопмент” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг улиран сонгох, томилох асуудал байна. За ердийн гишүүдэд нэр дэвшигчид бол Э.Баярбат, Ч.Солонго, Б.Чулуунсүх, Л.Алтангэрэл, С.Отгонсайхан, М.Дөлгөөн. Хараат бус гишүүдэд нэр дэвшигчид нь Э.Эрдэнэбаатар, Б.Баярмаа, Э.Ганбаатар гэсэн 9 хүн байна. Танилцуулгуудыг слайд дээр гялс гүйлгээд харуулчъя. Энэ хүмүүсийн 8 нь улиран сонгогдохоор байна. 1 хараат бус гишүүн маань анх удаа хүсэлт өгсөн байгаа. Энэ ТУЗ-ийн гишүүдийг сонгохтой холбоотойгоор санал асуулгын хуудас бөглөхдөө ердийн биш кумулятив аргыг сонгож бөглөнө. Тайлбар нь санал авах хуудастай хамт тарагдсан байгаа.

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Хүмүүстээ уншиж биш чиглүүлээд тайлбарлаад өгсөн нь зүгээр байх.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: Кумулятив аргаар санал өгөхдөө хувьцаа эзэмшигчид нь эзэмшиж буй хувьцааныхаа тоог ТУЗ-ийн 9 гишүүнийхээ тоогоор үржүүлнэ гэсэн үг 2,000,000 хувьцаа эзэмшиж байгаа хүн бол 18,000,000 саналтай болно гэсэн үг 18,000,000 саналаа энэ 10 гишүүдийнхээ алинд нь ч өгсөн болно. Өөрийнхөө дураар хуваагаад өгнө л гэсэн үг. 18,000,000 саналыг нь нэг хүнд өгчихсөн ч болно. Эсвэл 9 гишүүддээ тэгш хуваагаад бас хуваарилаад өгсөн ч болно гэсэн үг. Одоо та бүх эзэмшиж байгаа хувьцааны тоо бүрээ 9-өөр үржүүлнэ гэсэн үг. Тэгээд ТУЗ-д сонгогдох гэж байгаа нэр дэвшиж байгаа хүмүүстээ саналаа өгнө. Нэр дэвшигчид өгөх саналын тоо гээд байгаа.

ТУЗ-ийн 6 ердийн гишүүн, 3 хараат гишүүдийг томилох тогтоолын төсөл энэ байна. Унших уу?

Хувьцаа эзэмшигч Э.Баярбат: За тэр нь дээр.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Компанийн дүрмийн 3-р зүйлийн 3.13.7 дахь заалт, 2024 оны 04 сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь гээд гишүүдийн нэрс байна.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Чулуунсүх: Өөр нэмэлт асуулт, санал хүсэлт байхгүй бол ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудлууд дууслаа. Завсарлах явцад тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналыг тоолж, завсарлагааны дараа дүнгээ танилцуулах байгаа.

Тооллогын комиссын дарга Б.Мөнхзул: Хурал завсарлах явцад тооллогын комисс хуралдаж хувьцаа эзэмшигч нарын саналын хуудсын дүнг нэгтгэж тогтоол гаргав. Санал хураалтын нэгдсэн дүнгийн тухай “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

“Хот Девелопмент” ХК-ийн саналын эрх бүхий нийт 28,470,054 ширхэг хувьцаанаас 99.83% буюу 28,921,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Хот Девелопмент ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 28,921,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
28,921,521	100%	0	0%	0	0%

1. Хот Девелопмент ХК-ийн 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэг батлах асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 28,921,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
28,921,521	100%	0	0%	0	0%

2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төслийг батлах асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 28,921,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
28,921,521	100%	0	0%	0	0%

3. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай тогтоолыг батлах асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 28,921,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
28,921,521	100%	0	0%	0	0%

4. Хот Девелопмент ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг шинээр сонгох, томилох асуудалд кумулятив аргаар дараах байдлаар тус тус санал авч доорх нэр дэвшигчид ТУЗ-ийн гишүүдээр сонгогдов. Үүнд:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Э.Баярбат	11.11%	28,921,521
2	Ч.Солонго	11.11%	28,921,521
3	Л.Алтангэрэл	11.11%	28,921,521
4	Б.Чулуунсүх	11.11%	28,921,521
5	С.Отгонсайхан	11.11%	28,921,521
6	М.Дөлгөөн	11.11%	28,921,521

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Э.Ганбаатар	11.11%	28,921,521
2	Б.Баярмаа	11.11%	28,921,521
3	Э.Эрдэнэбаатар	11.11%	28,921,521

Ингэснээр хурал 11:55 минутанд өндөрлөв.

Хурлын тэмдэглэлийг баталгаажуулсан Хурлын дарга Э.Баярбат

Хурлын тэмдэглэл хөтөлсөн С.Отгонсайхан

